



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/228

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Ойн хортны тэмцлийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу “Гранд форест” ХХК-тай 1 дүгээр багцад 135 690 000 /нэг зуун гучин таван сая зургаан зуун ерэн мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.

2. “Гранд форест” ХХК-ийн гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Буманбаяр/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Гранд форест” ХХК /Б.Жавхлантөгс/-д даалгасугай.

4. Тус ажлыг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190242